

**“100000 Нарны гэр” хөтөлбөрөөр малчдад олгосон цахилгаан
үүсгүүрийн үнийн төлөлт, эргэлтийн сангийн бүрдүүлэлт**



**Эргэлтийн сан бүрдээгүй, түүнд
тавих хяналт хангалтгүй байна**

**УИХ-ын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хорооны
захиалгаар хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан**

**Улаанбаатар
2006 оны 10 дугаар сар**

Агуулга

Тайланг бэлтгэсэн:

ҮАГ-ын Хоёрдугаар газар

Тэргүүлэх аудитор
О.Мэндбаяр

Ахлах аудитор
Ц.Гэрэл

Шинжээч:
Л.Эрдэнэчулуун
Р.Цолмон

2006 оны 10 дугаар сар

Уг тайланг ҮАГ-ын
Веб сайт-аас үзнэ үү:

www.mnao.pmis.gov.mn

Аудитын тайлан, дүгнэлттэй
холбоотой асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах зүйл
байвал 263533 дугаарын утас,
323266 дугаарын факсаар
харилцана уу.

ХАЯГ:

Үндэсний аудитын газар
Засгийн газрын 4 дүгээр байр,
Бага тойруу-6, Улаанбаатар-46
Монгол Улс

Товчилсон үгийн жагсаалт 3

Аудитын зорилт, хамарсан
хүрээ, арга зүй 4

Аудитад ашигласан шалгуур,
стандартын мэдэгдэл 4

Ерөнхий зүйл 5

Бүлэг 1

Хөтөлбөрийн үе шатны зорилтууд бүрэн хэрэгжээгүй байна

- Хөтөлбөрийн зорилтот тоо хэмжээнд
хүртэл цахилгаан үүсгүүр
нийлүүлэгдээгүй байна..... 6
- Хуваарилалт, түгээлтийн явцад
хяналт тавиагүй байна..... 6
- Хөтөлбөрийн санхүүжилтээс зориулалт
бус зарцуулсан ба эргэж төлөгдөх
нөхцөлөөр олгосон зээл бүрэн
төлөгдөөгүй байна..... 7

Бүлэг 2

Эргэлтийн сангийн бүрдэлт хангалтгүй байна

- Цахилгаан үүсгүүрийн үнэ төлөгдөх
эрх зүйн үндэс..... 8
 - Эргэлтийн сангийн бүрдэлт, бүртгэл,
хяналт хангалтгүй байна..... 8
-

Бүлэг 3

Хөтөлбөрийн хяналт хангалтгүй байна

- Хөтөлбөрийн үе шатанд хараат бус хяналт шалгалт хийгдээгүй байна..... 10
- Санхүү, эдийн засгийн яам, Дэд бүтцийн яам, Аймгийн Засаг дарга нарын хооронд байгуулсан гэрээг дүгнээгүй байна..... 10
- Цахилгаан үүсгүүрийн ашиглалтад үнэлгээ хийж, хяналт тавих боломж байжээ..... 11
- Хөтөлбөрийн үр өгөөжийг дээшлүүлэх бололцоог ашиглаагүй байна..... 11

Санал

- Түлш, эрчим хүчний яамны санал..... 12
- Сангийн яамны санал..... 13
- Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төвийн санал..... 14

Хавсралт 15

Товчилсон үгийн жагсаалт:

ЗГ	ЗАСГИЙН ГАЗАР
СЯ	САНГИЙН ЯАМ
СЭЗЯ	САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ЯАМ
СЭЗС	САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД
ДБЯ	ДЭД БҮТЦИЙН ЯАМ
ДБС	ДЭД БҮТЦИЙН САЙД
ТЭХЯ	ТҮЛШ, ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ
ТЭХС	ТҮЛШ, ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД
АЗД	АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
СЭХҮТ	СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮНДЭСНИЙ ТӨВ
АЗДТГ	АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ТС	ТӨРИЙН САН
ШЦХГ	ШУУДАН ЦАХИЛГААН ХОЛБООНЫ ГАЗАР
СЭХЭҮ	СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ЭХ ҮҮСГҮҮР
НЗҮ	НАРНЫ ЗАЙН ҮЙЛДВЭР
ТН	ТӨСЛИЙН НЭГЖ
НЦҮ	НАРНЫ ЦАХИЛГААН ҮҮСГҮҮР
ЦҮ	ЦАХИЛГААН ҮҮСГҮҮР
ААГ	АЙМГУУДЫН АУДИТЫН ГАЗАР
БХШТХ	БАЙГУУЛЛАГЫН ХУГАЦААТАЙ ШАТАЛСАН ТУСГАЙ ХАДГАЛАМЖ

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Монгол Улсын Засгийн газрын “100000 нарны гэр” хөтөлбөрөөр малчдад олгосон цахилгаан үүсгүүрийн үнийн төлөлт, эргэлтийн сангийн бүрдүүлэлтийн байдлыг шалгаж, дүгнэлт гаргах, үр дүнг дээшлүүлэх санал, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.

Гүйцэтгэлийн аудитын үндсэн зорилтыг дараахь дэд асуудлуудад ангилсан. Үүнд:

1. “100000 Нарны гэр” хөтөлбөрийн үе шатны зорилтын хэрэгжилт
2. Эргэлтийн сангийн удирдлага, үр нөлөө
3. Хөтөлбөрийн хяналт, үр нөлөө

Аудитад ТЭХЯ, СЭХҮТ, хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэгжийг хамруулан үйл ажиллагааны тайлан, бусад холбогдох байгууллагын санхүүгийн баримт бичигт үндэслэн, холбогдох ажилтнуудтай ярилцлага хийх, тайлбар, мэдээ гаргуулах байдлаар аудитын шинжилгээний болон нарийвчилсан горимын дагуу сорил, дүн шинжилгээ хийх арга зүйг ашиглан гүйцэтгэв.

Аудитад ашигласан шалгуур, стандартын мэдэгдэл

Аудитад дараахь хууль эрхийн акт, баримт бичгийг шалгуур үзүүлэлт болгов.

1. Засгийн газрын “100000 Нарны гэр” хөтөлбөр
2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хууль
3. Засгийн газрын 2004 оны 81 дүгээр тогтоол
4. СЭЗЯ, ДБЯ, Аймгийн Засаг дарга нартай байгуулсан гэрээ
5. Холбогдох бусад хууль эрхийн актууд

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, Гүйцэтгэлийн шалгалтын журам, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан аудитын төлөвлөгөөг мөрдлөг болгов.

Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн шалгалтын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох судалгаа мэдээллийг ажлын баримт материалд хавсаргав.

Ерөнхий зүйл

Улсын Их Хурлын 1994 оны 198 дугаар тогтоолд “Усан цахилгаан станц байгуулах, нар салхиар ажилладаг жижиг оврын цахилгаан үүсгүүрээр хөдөөг хангахад зарцуулах хөрөнгийн гадаад, дотоод эх үүсвэрийг жил бүрийн төсөв, төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх”, 1996-2000 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт “Малчид зарим сум, суурин газрыг сэргээгдэх эрчим хүчээр хангах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу Засгийн газрын 1999 оны 158 дугаар тогтоолоор Сэргээгдэх эрчим хүч ашиглан хөдөөг цахилгаан эрчим хүчээр хангах “100000 Нарны гэр” үндэсний хөтөлбөрийг баталжээ.

Хөтөлбөрийн зорилго нь 2000-2010 онд хөдөөгийн нийт айл өрхийг нарны цахилгаан үүсгүүрээр хангах, малчин айл өрх, сум багийн төв, сургууль, эмнэлэг, аялал жуулчлалын бааз, соёл, ахуйн үйлчилгээний байгууллага, хилийн сумангийн цахилгаан эрчим хүчний хэрэгцээг хангах нар-салхи-усан цахилгаан станц хосолсон сэргээгдэх эрчим хүчний системийг дизель станцтай хослуулан ашиглах боломж бүхий цогцолборуудыг байгуулахад оршиж байна.

Дэд бүтцийн хөгжлийн сайдын (хуучин нэрээр) 2000 оны 128 дугаар тушаалаар хөтөлбөрийн удирдагчийг томилж, 2001 оны 2 дугаар тушаалаар хөтөлбөрийн удирдах нэгжийг байгуулан дүрмийг нь баталжээ.

Хөтөлбөрийн удирдах нэгжийг 2005 онд татан буулгаж, Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төвд нэгтгэсэн байна.

Бүлэг 1

Хөтөлбөрийн үе шатны зорилтууд бүрэн хэрэгжээгүй байна

1. Хөтөлбөрийн зорилтот тоо хэмжээнд хүртэл цахилгаан үүсгүүр нийлүүлэгдээгүй байна

1.1. Хөтөлбөрийн үе шатны зорилт, хэрэгжилтийг үзүүлбэл:

Хэрэгжих үе шат	I үе 2000 он	II үе 2001-2005 он	III үе 2005-2010 он
Зорилт	“100000 Нарны гэр” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 5000 айл өрхийг СЭХЭҮ-ээр хангах	СЭХЭҮ-ийн үйлдвэрлэлийн баазыг бэхжүүлж, 2000-2005 онд нийт 50000 айл өрхийг СЭХЭҮ-ээр хангах, ЭХ-ний төвлөрсөн системээс алслагдсан хэрэглэгчийг хангах нар-салхи- ус-дизель хосолсон цогцолборыг байгуулах	СЭХЭҮ-ээр манай орны хөдөөгийн нийт айл өрхийг хангаж, сум, багийн төв, аялал жуулчлалын бааз суурин газрыг цахилгаанжуулах ажлыг өргөжүүлэх
ЦҮ-ийн тоо, чадал	5000 ширхэг 0.25 Мегаватт	45000 ширхэг 2.25 Мегаватт	50000 ширхэг 2.5 Мегаватт
Хангагдсан байдал			
Нийлүүлсэн ЦҮ-ийн тоо,	740 ширхэг	31790 ширхэг	2005-2006 онд малчин өрхөд нарны цахилгаан үүсгүүр нийлүүлээгүй байна.
Хугацаа	2001 он	2003-2004 он	

Хөтөлбөрийн зорилт ёсоор 2005 оны эцэст нийт 50000 малчин өрх, 2,5 мегаватт нийлбэр хүчин чадал бүхий ЦҮ-ээр хангагдахаас:

- 2001 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтын дэмжлэгтэйгээр ШЦХГ-ын НЗҮ-т үйлдвэрлэсэн 740 ширхэг,
- 2002-2004 онд Япон Улсын ЗГ-ын төслийн бус буцалтгүй тусламжаар 11170 ширхэг,
- 2004 онд БНХАУ-ын ЗГ-ын буцалтгүй тусламжаар 3 төрлийн 20620 ширхэг буюу бүгд 32530 ЦҮ нийлүүлэгдэж, малчин өрхийн судалгаа болон орон нутгаас авсан захиалгад үндэслэн хуваарилсан бөгөөд хөтөлбөрийн 1, 2 дугаар үе шатны зорилт 65,0 хувиар биелж, нийлбэр хүчин чадал 1,7 мегаваттад хүрсэн байна.

2. Хуваарилалт, түгээлтийн явцад хяналт тавиагүй байна

2.1. Япон Улсын тусламжаар нийлүүлсэн ЦҮ-ийг 2003 оны 11 дүгээр сарын 1-ний дотор, БНХАУ-ын буцалтгүй тусламжаар нийлүүлсэн ЦҮ-ийг 2004 оны 10 дугаар сарын 1-ний дотор хөдөөгийн малчдад хүргэхийг СЭЗС, ДБС-ын хамтарсан тушаалаар холбогдох байгууллагад үүрэг болгосон байна.

2.2. Гэвч орон нутагт хүргүүлсэн зарим ЦҮ-ийг захиалгын дагуу гэрээ байгуулж олгоогүй, харъяаллын бус хүмүүст олгох зэргээр хяналтгүй түгээсэн байна. Тухайлбал, Баян-Өлгий аймагт аймгийн төв, сумдад баримтгүй тараасан,

цохолтоор олгож тэдгээр нь малчдад хүрсэн эсэх нь тодорхойгүй, Архангай аймагт ИТХ-ын төлөөлөгч тарааж байсны дээр сумдад биечлэн хүргэж өгөөд тооцоо нийлээгүй байгаа 195,0 сая төгрөгийн 1333 ширхэг ЦҮ-ийн үлдэгдэлтэй, Завхан, Хэнтий аймагт УИХ-ын гишүүдийн итгэмжлэгдсэн төлөөлөгчид ТН-ээс авч аймгаар дамжуулалгүй тараасан, Дорноговь, Дархан-Уул, Булган, Өмнөговь, Хөвсгөл аймагт Хилийн цэрэг, Онцгой байдлын хэлтэс зэрэг газруудад олгосон нь ашиглалтгүй байсан зэрэг зөрчил илэрлээ.

2.3. ТН-ийн тайланд дурдсан ЦҮ-ийн тоо хэмжээ болон ачуулсан баримтын тоо ААГ-ын гаргасан тоо баримтаас зөрүүтэй байгаа нь хуваарилалтын хяналтгүй байдлаас шалтгаалж байна.

Д/д	НЦҮ-ийн Чадал	Төслийн нэгж		Аудитаар гарсан		Зөрүү	
		тоо	Үнэ	Тоо	үнэ	тоо	Үнэ
1	62 Вт	11,170	2,066.4	11,142	2,061.2	28	5.1
2	75 Вт	2,790	739.3	2,680	710.2	110	29.1
3	50 Вт	13,860	2,467.0	13,420	2,388.7	440	78.3
4	20 Вт	3,970	317.6	3,949	315.9	21	1.6
	Дүн	31,790	5,590.4	31,191	5,476.1	599	114.3

/сая.төгрөгөөр/

3. Хөтөлбөрийн санхүүжилтээс зориулалт бусаар зарцуулсан ба эргэж төлөгдөх нөхцөлөөр олгосон зээл бүрэн төлөгдөөгүй байна

3.1. Засгийн газраас ЦҮ-ийг үйлдвэрлэхэд зориулан улсын төсвөөс санхүүжигдэх эх үүсвэрийг арилжааны банкинд байршуулах, тусламжийн ЦҮ-ийн иж бүрдлийг угсрах, хадгалах, тээвэрлэх, ТН-ийн үйл ажиллагаа, сургалт, сурталчилгааны ажлыг санхүүжүүлэхтэй холбогдох зардлыг улсын төсвийн хөрөнгө оруулалтад тусгах зэргээр санхүүжилт олгох үүргээ биелүүлж иржээ.

3.2. “100000 Нарны гэр” хөтөлбөрийн хэрэгжилтэд зориулан 2001-2005 онд улсын төсвөөс нийт 465,3 сая төгрөг зарцуулжээ. Хөтөлбөрийн санхүүжилтийн тайлагнал, санхүүгийн баримт материалаас үзэхэд 8,8 сая төгрөгийг ДБЯ-ны байрны өмнөх гэрэлтүүлгийг хийхэд зарцуулсан нь зориулалт бус тул төлүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

3.3. СЭЗС, ДБС-ын 2003 оны ТЗ-САН-2003-08 тоот гэрээгээр ЦҮ-ийн зарим эд ангийг дотоодод үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэн хүргэхэд гарах зардлыг эргэн төлөгдөх зээлээр улсын төсвөөс 382,4 сая төгрөгөөр санхүүжүүлэх, ашигласан хөрөнгийг ЦҮ-ийн борлуулалтын орлогоос 2004 оны 10 дугаар сард багтаан төлүүлэхээр эрх, үүргийн харилцаа зохицуулагдсан ч гэрээт хугацаанд зээлийн хөрөнгө төлөгдөөгүй бөгөөд 2006 оны 9 дүгээр сарын байдлаар 199,2 сая төгрөгийн үлдэгдэлтэй, СЭЗЯ, ТС, ДБЯ-аас зээлийг төлүүлэх талаар тодорхой арга хэмжээ аваагүй байна.

Зөвлөмж: Түлш, эрчим хүчний сайд Б.Эрдэнэбатад дараахь зөвлөмжийг өгч байна:

1. Цахилгаан үүсгүүрийг хуваарилж, түгээх, хяналт тавих механизмийг оновчтой болгох арга хэмжээ авах,
2. Олгогдсон хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, төсвийн зээлийг буцаан төлүүлэх арга хэмжээ авах,

Бүлэг 2

Эргэлтийн санг бүрдүүлж чадаагүй байна

4. Цахилгаан үүсгүүрийн үнэ төлөгдөх эрх зүйн үндэс

4.1. “Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай” хуулийн 11 дүгээр зүйлд Засгийн газрын бүрэн эрх тодорхойлогдсон ба мөн хуулийн 12.1.5-д “Монголбанкинд ... гадаадын тусламжийн барааны борлуулалтын орлогын данс нээх, орлого төвлөрүүлэх, эргэлтийн сан байгуулах, төлбөр тооцоо хийх” гэж заасны дагуу эргэлтийн сангийн үйл ажиллагаа явагдаагүй байна.

4.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2004 оны 81 дүгээр тогтоолоор тусламжаар нийлүүлэгдсэн ЦҮ-ийн үнийг 50 хувиар хөнгөлөх, ЦҮ-ийн төлбөрөөс эргэлтийн сан байгуулж, түүнийг хөдөөгийн иргэдийг нарны цахилгаан үүсгүүрээр хангахад зарцуулж байхаар тогтоосон байна.

4.3. Гэвч орон нутагт хүргүүлсэн ЦҮ-ийн хуваарилалт, түгээлт хяналтгүй, гурвалсан гэрээний дагуу банкаар дамжуулан гэрээ хийлгүй олгосон зөрчил түгээмэл байснаас төлбөр хариуцагчийг тодорхойгүй болгох, үнийн эргэн төлөлтийн эрх зүйн үндсийг бүрхэгдүүлсэн байна.

5. Эргэлтийн сангийн бүрдэлт, бүртгэл, хяналт хангалтгүй байна

5.1. УИХ-ын болон орон нутгийн сонгуулийн үеэр ЦҮ-ийг үнэ төлбөргүй олгосон мэтээр Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Завхан, Өвөрхангай, Хөвсгөл зэрэг аймагт сурталчилж, ташаа ойлголтыг өгч байсан нь үнийн эргэн төлөлт, эргэлтийн сангийн бүрдэлтэд сөргөөр нөлөөлжээ.



5.2. Мөн ЦҮ-ийн үнэ арилжааны банк болон хэд хэдэн байгууллагын дансанд төвлөрч, ашиглагдсан, зөвхөн СЯ-ны ТС-д гэхэд л зээл, тусламжийн холбогдолтой 1-8 дансанд бүртгэгдсэн, төвлөрсөн данс солигдсон, эзэн тодорхойгүй баримт бүртгэгдсэн, ТН-ийн “Зоос” банкин дахь дансанд болон бэлнээр авч байсан зэрэг нь төлөлтийг бүрэн бүртгэх, хяналт тавих боломжийг алдагдуулсан байна. Тухайлбал,

- Өвөрхангай аймагт “Дэлгэрэх-Арвай” ХЗХ-ны дансанд ЦҮ-ийн үнэ 5,8 сая төгрөг ташаарч оруулсныг одоо болтол аваагүй, “Ар Агуйн Эрдэнэ” ХХК-иас ЦҮ худалдан авах нэрийдлээр гэрээ хийж 30,0 сая төгрөгийг 6 сар ашиглуулсан.

- Хөвсгөл аймагт Анод Банкны “Селько Монголия” ХХК-ийн дансанд 1292.4 мянган төгрөг, Зоос Банкны “Ар жанар” ХХК-ийн дансанд 3540.0 мянган төгрөг төлснийг зохих дансанд төвлөрүүлээгүй.
- Баянхонгор аймагт 35,5 сая төгрөгийг сумдын ЗДТГ-ын үйл ажиллагаа болон Засаг дарга нарыг Япон улсад үзэсгэлэн, семинарт оролцуулахад, 4,1 сая төгрөгийг Баянхонгор сумын Засаг дарга асан Г.Жадамбаа багийн конторын барилга бариулахад зарцуулснаас гадна хувьдаа 4,2 сая төгрөгийн зээл авсан байна. Мөн Жинст сумын Засаг дарга асан Мягмарсүрэн 5,7 сая төгрөг малчдаас бэлнээр авч Тамгын газрын үйл ажиллагаанд баримтгүй зарцуулжээ.

5.3. ЦҮ-ийн үнийн эргэн төлөлт нэгдсэн дансны зохицуулалтгүй, удирдлагагүй, хяналтгүйгээс шалтгаалж эргэлтийн сан бүрэн бүрдэж чадаагүй, төвлөрсөн хөрөнгийг зориулалт бусаар ашиглах явдал гарсан байна.

5.4. 2006 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар нийт төвлөрвөл зохих 5535,6 сая төгрөгийн 45,9 хувь буюу 2541,9 сая төгрөг ТС болон ХААН банкин дахь дансанд хуримтлагджээ. Аймгуудаар авч үзвэл Баян-Өлгий 0.9, Хэнтий 1.6, Төв 11.2, Архангай 15.9, Баянхонгор 21.1 хувийн эргэн төлөлттэй байна. */Хавсралт №1-ийг үзнэ үү/*



5.5. СЭЗС, ДБС-ын 2004 оны 149/125 дугаар тушаалын ХААН банкт байгуулсан 2003 оны гэрээнд нэмэлт оруулах заалт, Засгийн газрын 2005 оны 160 дугаар тогтоол, ТЭХС-ын 2005 оны 01/1410 дугаар албан бичигт үндэслэн ТЭХЯ, ХААН банк хоорондын 2006 оны 8 дугаар гэрээгээр хөтөлбөрийн санхүүжилттэй холбоотой эх үүсвэрийг байршуулах, эргэлтэд оруулах зорилгоор малчдын авсан ЦҮ-ийн төлбөрийг болон дансны тогтвортой үлдэгдлийг БХШТХ-ийн дансанд төвлөрүүлж ирсэн ба СЭХҮТ нь БХШТХ-ийн хүүг харилцах дансандаа авч зарцуулж иржээ.

5.6. Эргэлтийн сан бүрэн бүрдээгүй, сангаас хийх төлбөр, тооцооны нэгдсэн зохицуулалтгүй байгаа тул БХШТХ-ийн хүүг зарцуулсан нь буруу байна.

Зөвлөмж: Түлш, эрчим хүчний сайд Б.Эрдэнэбат, Сангийн сайд Н.Баяртсайхан нарт дараахь зөвлөмжийг өгч байна:

1. Цахилгаан үүсгүүрийн үнийг нэгдсэн дансанд төвлөрүүлэх зохицуулалт хийх,
2. Эргэлтийн санг бүрдүүлэх, зарцуулах журам боловсруулж мөрдүүлэх,
3. Цахилгаан үүсгүүрийн үнийн эргэн төлөлттэй холбоотой орон нутагт гарч буй зөрчлийг шийдвэрлүүлэх,

Бүлэг 3

Хөтөлбөрийн хяналт хангалтгүй байна

6. Хөтөлбөрийн үе шатанд хараат бус хяналт шалгалт хийгдээгүй байна

6.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэгж аж ахуйн тооцоон дээр төсвөөс олгох техник хяналтын зардлын санхүүгийн эх үүсвэрээр ажиллаж, жил, улирлын санхүүгийн тайлан, тэнцлийг гаргаж байх дүрэмтэй ажээ.

6.2. Гэвч хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэгжээс ЦҮ-ийг орон нутагт хуваарилсан үйл ажиллагааны тайлан бичигдэж байснаас бус санхүүгийн тайлан гаргаагүй, санхүүгийн холбогдох баримтыг СЭХҮТ хүлээж аваагүй байснаас санхүүгийн тайланд нь аудит хийж чадаагүй болно.

6.3. Хөтөлбөрийн үе шатанд хараат бус хяналт шалгалт хийгдээгүй бөгөөд зөвхөн ТЭХЯ-ны 2006 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагааны баримтад 1 удаа шалгалт хийгдсэн байна.

7. СЭЗЯ, ДБЯ, АЗД нарын хооронд байгуулсан гэрээг дүгнээгүй байна

7.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд СЭЗС, ДБС-ын 2003 оны 264/197 дугаар тушаалын дагуу малчдад зээлээр ЦҮ олгох талаар СЭЗЯ, ДБЯ болон аймгийн Засаг дарга нарын хооронд хамтран ажиллах гэрээ байгуулжээ.

7.2. Энэхүү гэрээгээр АЗДТГ нь ХААН Банктай хамтран ажиллаж, ЦҮ-ийн үнийг бүрэн төлүүлэх талаар сумын Засаг дарга нартай гэрээ байгуулан гэрээний биелэлтэд хяналт тавихаар заагдсан ч шат шатандаа гэрээний заалт бүрэн хэрэгжээгүй дутагдал түгээмэл гарч, талууд гэрээг хамтран дүгнээгүй, зарим аймгийн удирдлага тодорхой үр дүнтэй ажил зохион байгуулаагүй байна. Тухайлбал, Баян-Өлгий аймгийн аудитын газраас ЦҮ-ийн үнийг төлүүлж, санд төвлөрүүлэх санал оруулсан боловч Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар ЦҮ-ийн үнэ эргэж төлөгдөх ямар ч боломжгүй гэдгийг Засгийн газарт уламжлахаар шийдвэрлэн хуралдааны тэмдэглэлээ аймгийн аудитын газарт ирүүлсэн нь хөтөлбөрийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж, тухайн аймгийн бусад малчин өрхийг ЦҮ-ээр хангах боломжийг бууруулж байна.

7.3. ААГ-аас хийсэн аудитаар илэрсэн зөрчил, дутагдлыг тайланд тодорхой тэмдэглэн холбогдох байгууллага, албан тушаалтанд зөвлөмж өгсний дээр илэрсэн төлбөр, зөрчлийг арилгуулахаар бүгд 472,3 сая төгрөгийн 18 төлбөрийн акт тавьж, эзэн холбогдогчийг олж тогтоох, төвлөрсөн дансанд шилжүүлээгүй болон тооцоо нийлээгүй ЦҮ-ийн үнийг төлүүлэх 910,2 сая төгрөгийн албан шаардлага өгсөн байна. /Хавсралт №2-ийг үзнэ үү/

8. Цахилгаан үүсгүүрийн ашиглалтад үнэлгээ хийж, хяналт тавих боломж байжээ

8.1. Хөтөлбөрийн эхний шатанд аймгуудын Холбооны газрын мэргэжилтнийг 1-2 удаагийн сургалтад хамруулан гэрчилгээ олгож ЦҮ-ийн ашиглалтын заавар, танилцуулгыг өгсөн байна.

8.2. Гэвч хуваарилагдсан ЦҮ-ээс ашиглалтын шаардлага хангахгүй, гэмтэлтэй ЦҮ Ховд, Завхан аймагт гарч буцаагдсан мэдээ байгаа ч ТН дээр ЦҮ-ийн үлдэгдэл байхгүй, ашиглалтын явцад үнэлгээ хийж, хяналт тавьж байсан талаархи ажлын баримт материал алга байна.

9. Хөтөлбөрийн үр өгөөжийг дээшлүүлэх нөөц бололцоог ашиглаагүй байна



9.1. Засгийн газрын 2004 оны 81 дүгээр тогтоолоор ЦҮ-ийн үнийг 50 хувиар хямдруулсан, мөн зах зээлд зарагдаж буй ЦҮ-ээс үнэ, чанарын хувьд хямд, давуу зэрэг нь худалдан авах сонирхлыг илүүтэй бий болгож төлбөрийг шууд болон эргэж төлөгдөх нөхцөлөөр хийх хүсэлт, захиалга нэмэгдсэн байна.


9.2. Гэвч хөтөлбөрийн зорилтыг бүрэн хэрэгжүүлэхийн тулд эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн эргэлтийн сангийн эргэцийг сайжруулах, төвлөрсөн хөрөнгийг ашиглан НЗҮ-т цахилгаан үүсгүүр үйлдвэрлэж малчин өрхийг хангах ажил 2005-2006 онд хийгдээгүй, уг үйлдвэр дээрх хугацаанд бүрэн хүчин чадлаараа ажиллаагүй, үндсэндээ сул зогссон байна.



Зөвлөмж: Түлш, эрчим хүчний сайд Б.Эрдэнэбатад дараахь зөвлөмжийг өгч байна:

1. Хөтөлбөрийн хэрэгжүүлэгч, оролцогч талуудын үүрэг хариуцлагыг тодорхой болгож, биелэлтийг нь тооцож тайлагнаж байх,

ТЭХ-ний сайдаас ирүүлсэн санал



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОР Л.ЖАВЗМАА ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ТҮЛШ, ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД**
210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/Факс: 31-81-69

2006.11.15 № 9/2000
танай _____-ны № _____-г

Санал хүргүүлэх тухай


УИХ-ын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хорооны хүсэлтээр “100000 Нарны гэр хөтөлбөрөөр малчдад олгосон цахилгаан үүсгүүрийн үнийн төлөлт, эргэлтийн сангийн бүрдүүлэлт”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Аудитын тайлангийн төсөлд зарчмын хувьд тодорхой саналгүй бөгөөд дараах заалтуудад тайлбар хийх хүсэлтэй байна. Үүнд:


Аудитын тайлангийн төслийн 4.1-д “Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай” хуулийн 12.1.5-д “Монголбанкнд ... гадаадын тусламжийн барааны борлуулалтын орлогын данс нээх, орлого төвлөрүүлэх, эргэлтийн сан байгуулах, төлбөр тооцоо хийх” гэж заасны дагуу эргэлтийн сан байгуулах тухай саналаа Сангийн яаманд 2006 оны 3 дугаар сарын 13 өдрийн а/408 тоотгоор хүргүүлсэн боловч одоогоор саналын хариу ирүүлээгүй байна.

Тайлангийн төслийн 6.3-т “Хөтөлбөрийн үе шатанд хараат бус хяналт хийгдээгүй ...” гэжээ Түлш, эрчим хүчний яамны Төрийн захиргааны удирлагын газраас “100000 нарны гэр” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний тайлан”-г яамны Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн зохих шийдвэр гаргуулан ажиллаж байна.

Дараах материалуудыг хавсаргав.


- Түлш, эрчим хүчний сайдын 2006 оны 3 дугаар сарын 13 өдрийн а/408 тоот албан бичиг 1 хуудас.
- Түлш, эрчим хүчний сайдын зөвлөлийн хуралдааны 2006 оны 9 дугаар сарын 05 өдрийн 6 дугаар тэмдэглэл 1 хуудас.
- 100000 нарны гэр” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний тайлан 30 хуудас.

 САЙД


Б.ЭРДЭНЭБАТ

0600602

Сангийн сайдаас ирүүлсэн санал



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД
210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: 26-02-47, <http://www.mof.gov.mn>

2006.11.30 № 6-8/5101
танай _____ -ны № 3/395 -т

Тоотын хариу

“100000 Нарны гэр” хөтөлбөрөөр малчдад олгосон цахилгаан үүсгүүрийн үнийн төлөлт, эргэлтийн сангийн бүрдүүлэлт”-д хийсэн гүйцэтгэлийн аудитийн тайлангийн төслийн талаар дараах саналтай байна. Үүнд:

Зөвлөмж 1. Цахилгаан үүсгүүрийн үнийг нэгдсэн дансанд төвлөрүүлэх зохицуулалт хийх,


Санал: Нарны цахилгаан үүсгүүрийн төлбөрийг төрийн сангийн нэгдсэн дансанд төвлөрүүлж байгаа тул нэмэлт зохицуулалт шаардлагагүй гэж үзэж байна. Зарим аймгуудад Засаг даргын Тамгын газрын хариуцлагагүй үйлдлээс төлбөрийг өөр дансанд төвлөрүүлсэн байсныг залруулах, холбогдох хууль, журмын дагуу эдгээр асуудлуудыг шийдвэрлүүлэх чиглэлээр ажиллаж байна.

Зөвлөмж 2. Эргэлтийн санг бүрдүүлэх, зарцуулах журам боловсруулж мөрдүүлэх,

Санал: Энэхүү зөвлөмжийг зарчмын хувьд дэмжиж байна. Сангийн яамны хувьд тухайлсан журам бус гадаад орнуудаас төслийн бус буцалтгүй тусламжаар нийлүүлэгдэж байгаа барааны орлогыг төлөвлөх, зарцуулах, хяналт тавих, эргэн төвлөрүүлэх, бүртгэх, тайланд тусгах харилцааг зохицуулах ерөнхий журмыг эцэслэн боловсруулаад байна. Цаашид өмнөх болон дараагийн төслийн бус буцалтгүй тусламжийн холбогдох харилцаа нь энэхүү журмаар зохицуулагдах болно.

Зөвлөмж 3. Цахилгаан үүсгүүрийн үнийн эргэн төлөлттэй холбоотой орон нутагт гарч буй зөрчлийг шийдвэрлүүлэх,

Санал: Энэ асуудлаар Сангийн сайд, Түлш, эрчим хүчний сайдын 2006 оны 10 дугаар сарын 9-ний өдрийн 311/89 тоот хамтарсан тушаалаар байгуулсан Нарны цахилгаан үүсгүүр малчдад зээлээр олгосон хамтарсан гэрээг дүгнэх ажлын хэсэг нь орон нутагт тараагдсан нийт цахилгаан үүсгүүрийн эздийг тогтоох, хамтарсан гэрээг дүгнэх, өр төлбөрийг барагдуулах, зөрчил, дутагдлыг арилгуулах чиглэлээр ажиллаж байгааг мэдэгдэх байна.


Н.БАЯРТСАЙХАН
08 4217

СЭХҮТ-өөс ирүүлсэн санал



ТҮЛШ, ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ
СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ
ҮНДЭСНИЙ ТӨВ

210136 Улаанбаатар хот, ш/х479,
Хан-Уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө
Утас: 342377, 342375, Факс: 342377
E mail: reenergy@magicnet.mn
Web: www.reenergy.com

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

2006-11-08 № 614
ТАНАЙ _____ -ны _____ -т

*“100000 нарны гэр” хөтөлбөрийн
гүйцэтгэлийн аудитын тухай*

“100000 нарны гэр” үндэсний хөтөлбөрийн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцаж, өгөгдсөн дүгнэлт, зөвлөмжийг цаашдын ажилдаа мөрдлөг болгон ажиллахаар мэдэгдэхийн хамт дараах тайлбарыг өгч байна. Үүнд:

1. Санхүү эдийн засгийн яам, Дэд бүтцийн яам, аймгуудын Засаг даргын тамгын газруудтай байгуулсан гэрээг дүгнэж Нарны цахилгаан үүсгүүрийн төлбөрийн дутууг барагдуулахаар Сангийн сайд, Түлш, эрчим хүчний сайдын 2006 оны 10 сарын 9-ны өдрийн 311/89 тоот хамтарсан тушаалаар комисс томилогдон ажиллаж байна.

2. Хөтөлбөрийг цаашид тасралтгүй үргэлжлүүлэн хэрэгжүүлэхэд тус төвийн Нарны зайн үйлдвэрийн хүчин чадлыг ашиглан 2007 онд 5000 нарны цахилгаан үүсгүүрийг үйлдвэрлэн малчдад нийлүүлэхээр төлөвлөн холбогдох шийдвэрийг Сангийн яам, ТЭХЯ-наас гаргуулахаар ажиллаж байна.

3. Нарны цахилгаан үүсгүүрийн хуваарилалт, түгээлт болон эргэлтийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалтын журам боловсруулан Сангийн яам, ТЭХЯ-аар батлуулан мөрдөж ажиллахаар төлөвлөж байна.

4. Санхүү эдийн засгийн сайд, Дэд бүтцийн сайдын 2003 оны ТЗ-САН-08, тоот эргэн төлөгдөх зээлийн гэрээгээр 382,4 сая төгрөгийг Японы төслийн бус буцалтгүй тусламжаар нийлүүлэгдсэн нарны цахилгаан үүсгүүрийн удирдлагын хайрцаг болон нарны зайн суурь, тулгуурийн иж бүрдлийг хийхэд зориулалтын дагуу бүрэн зарцуулж тайлан тооцоог хүргүүлсэн. Харин түүний дутуу төлөлт болох 199,2 сая төгрөгийг Япон улсын төслийн бус буцалтгүй тусламжийн нарны цахилгаан үүсгүүрийн борлуулалтын орлогоос төлөхөөр гэрээнд заасан тул Сангийн яамны Төрийн сангийн данс дахь эргэлтийн хөрөнгөнөөс тооцон суутгуулах нь зүйтэй гэж үзэж байна.

5. Албан шаардлагын жагсаалтын 14-р зүйлд 100000 нарны гэр хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зарцуулах хөрөнгөнөөс 8,785,5 мянган төгрөгийг тухайн үеийн Дэд бүтцийн яамны шийдвэрээр Солонгосын Засгийн газраас хэрэгжүүлсэн буцалтгүй тусламжийн төслийн дотоодын зардалд зориулсан болно.



 Н.ЭНЭБИШ

**“100000 Нарны гэр” хөтөлбөрөөр малчдад олгосон цахилгаан
үүсгүүрийн үнийн төлөлт, эргэлтийн сан бүрдүүлэлт**

Хавсралт №1

“100000 НАРНЫ ГЭР” ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД НЦҮ-ИЙН ҮНИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН ТОВЧОО

Д.д	Аймаг, хот	Төлбөрийн хэмжээ	Төвлөрүүлсэн хэмжээ /оноор/			Нийт хэмжээ	Төлөлтийн хувь
			2004	2005	2006		
1	Архангай	367,365.0	15,078.0	42,586.0	1,037.4	58,701.4	15.98
2	Баян-Өлгий	554,080.0		5,195.1	235.0	5,430.1	0.98
3	Баянхонгор	495,852.0	12,259.8	21,068.0	71,725.6	105,053.4	21.19
4	Булган	194,161.0	86,603.3	77,762.7	8,659.9	173,025.9	89.11
5	Говь-Алтай	550,050.0	160,080.2	119,620.0	100,000.0	379,700.2	69.03
6	Говьсүмбэр	17,650.0	6,134.0	5,466.0	3,791.0	15,391.0	87.20
7	Дархан-Уул	34,400.0	1,527.5	6,267.0	524.0	8,318.5	24.18
8	Дорнод	134,080.0	29,786.8	46,376.7	16,377.6	92,541.1	69.02
9	Дорноговь	70,425.0	5,735.0	22,010.0	25,350.0	53,095.0	75.39
10	Дундговь	215,972.0	4,205.0	138,142.9	21,258.8	163,606.7	75.75
11	Завхан	460,172.0	60,046.5	127,574.1	39,855.6	227,476.2	49.43
12	Орхон	22,150.0	7,854.1	1,645.0	5,049.0	14,548.1	65.68
13	Өвөрхангай	368,185.0	661.0	60,700.9	79,041.7	140,403.7	38.13
14	Өмнөговь	126,650.0	1,175.0	72,294.9	9,500.0	82,969.9	65.51
15	Сүхбаатар	395,600.0	94,303.2	120,655.0		214,958.2	54.34
16	Сэлэнгэ	68,900.0	3,040.0	2,248.0	33,000.0	38,288.0	55.57
17	Төв	70,065.0	331.0	2,214.0	5,340.0	7,885.0	11.25
18	Увс	288,676.0	82,843.6	33,699.6	16,222.0	132,765.2	45.99
19	Ховд	614,502.0	140,272.8	156,390.1	93,609.5	390,272.4	63.51
20	Хөвсгөл	356,095.0	104,543.1	104,709.8	22,619.2	231,872.1	65.12
21	Хэнтий	122,645.0	550.0	1,245.0	185.0	1,980.0	1.61
22	УБ дүүрэг	7,920.0		3,630.0		3,630.0	45.83
	ДҮН	5,535,595.0	817,029.8	1,171,500.8	553,381.3	2,541,911.9	45.92
	ХУВЬ		32.1	46.1	21.8	100.0	

“100000 Нарны гэр” хөтөлбөрөөр малчдад олгосон цахилгаан үүсгүүрийн үнийн төлөлт, эргэлтийн сан бүрдүүлэлт

Хавсралт №2

“100000 НАРНЫ ГЭР” ХӨТӨЛБӨРӨӨР МАЛЧДАД ОЛГОСОН ЦҮ-ИЙН ҮНИЙН ТӨЛӨЛТ, ЭРГЭЛТИЙН САНГИЙН БҮРДҮҮЛЭЛТ”-Д ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТААР ТАВЬСАН АКТ, АЛБАН ШААРДЛАГЫН ЖАГСААЛТ

Д.д	Аудитын газар	Актын			Албан шаардлагын		
		Дүн	Хариуцах байгууллага, албан тушаалтан	Тайлбар	дүн	Хариуцах байгууллага, албан тушаалтан	Тайлбар
1	Архангай				304,458.6	Аймгийн ЗДарга	ЦҮ-ийн үнэ төлүүлэх,
2	Баянхонгор	9,968.0	Аймаг, сумдын ЗДТГ-ын ажилтан	Төвлөсөн хөрөнгийг ашигласан			
3	Булган	3,936.4	АЗДТГ-ын ажилтан нар	ЦҮ-ийн үнэ төлүүлэх			
		8,967.7	АЗДТГ-ын ажилтан	Үнийн дутууг нөхөн төлүүлэх,			
4	Говь-Алтай	10,864.7	АЗДТГгазар	ЦҮ-ийн үнийг төвлөрсөн дансанд төвлөрүүлээгүй	126,257.2	АЗДаргын орлогч	ЦҮ-ийн үнийг төлүүлэх
5	Дорноговь				34,125.0	Аймаг, сумдын ЗДТГ-ын ажилтан	Зөрчлийг арилгах тухай
6	Завхан	203,267.0	Аймаг, сумдын ЗДТГгазар	ЦҮ-ийн үнийг төвлөрүүлэх тухай			
7	Орхон	4,534.0	Баян-Өндөр сумын ЗДарга	ЦҮ-ийн үнийн төлөлтийн дутууг төлүүлэх			
		997.2	Жаргалант сумын ЗДарга	ЦҮ-ийн үнийн төлөлтийн дутууг төлүүлэх			
		582.0	Жаргалант сумын ЗДарга	ЦҮ-ийн үнийн төлөлтийн дутууг төлүүлэх			
8	Өвөрхангай	6,080.0	АЗДТГ-ын ҮДББОБЗХэлтэс	ЦҮ-ийн үнийг ААН-д шилжүүлж ашиглуулсан	177,306.5	АЗДТГ-ын ҮДББОБЗХэлтэс	ЦҮ-ийн үнэ төлүүлэх,
		720.0	АЗДарга, ЗДТГ, ҮДББОБЗХэлтэс	Төвлөрсөн хөрөнгийг ашиглуулсан	1,000.0	АЗДТГ-ын мэргэжилтэн	ЦҮ-ийн үнийг төлүүлэх
9	Сэлэнгэ	178.0	Иргэн Одмандах	ЦҮ-ийн үнийг төлүүлэх			
		356.0	Мөнх даатгал ХХК	ЦҮ-ийн үнийг төлүүлэх			
10	Төв				16,441.0	АЗДТГ-ын ҮДББОБЗХэлтэс	ЦҮ-ийн үнийг төвлөрүүлэх
11	Увс				8,900.0	СЭХҮТөв, ТНэгж	ЦҮ-ийн зөрүүг тогтоох
					73,504.0	АЗДТГ, холбогдох мэргэжилтэнүүд	ЦҮ авсан эздийг тогтоох
					87,149.8	АЗДТГ, холбогдох мэргэжилтэнүүд	Төв дансанд төвлөрүүлэх
12	Ховд	117,697.7	АЗДТГ-ын ҮДББОБЗХэлтэс	ЦҮ-ийн үнийг төвлөрсөн дансанд төвлөрүүлээгүй			
		10,000.0	АЗДТГ-ын ҮДББОБЗХэлтэс	Төвлөрүүлсэн хөрөнгийг ашиглуулсан			
		58,321.0	АЗДТГ-ын ҮДББОБЗХэлтэс	ЦҮ-ийн үнийг 2006.12.15-ны дотор төлүүлэх			
13	Хөвсгөл	6,989.0	АЗДТГ, холбогдох ажилтнууд	Дутагдуулсан ЦҮ-ийн үнийг нөхөн төлүүлэх	81,142.0	АЗДТГ, холбогдох ажилтнууд	ЦҮ-ийн үнийг төлүүлэх
		20,072.0	АЗДТГ, холбогдох ажилтнууд	ЦҮ-ийн үнийг төвлөрсөн дансанд төвлөрүүлээгүй			
14	ҮАГ	8,785.5	ТЭХЯ, СЭХҮТөв	Зориулалт бус зардал			
	Нийт дүн	472,316.2			910,284.1		